



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Жанжин Д.Сүхбаатарын талбай 7, 1 дүгээр хороо,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160-0035
Утас/Факс: (976-11) 32-71-99,
<http://www.ulaanbaatar.mn>

2020. 02. 14 № 03/777
танай _____-ны № _____-т

НИЙСЛЭЛИЙН НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГУУДАД

Нийслэлийн Засаг даргын 2020 оны “Өндөржүүлсэн бэлэн байдлын үед авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” А/191 дүгээр захирамж, Нийслэлийн Онцгой комиссын 03 дугаар хурлын тэмдэглэл, Онцгой комиссын даргын “Үүрэг хүргүүлэх тухай” 59 дүгээр албан бичгийг тус тус хүргүүлэв.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 62 дугаар тогтоолоор Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг хангуулж, шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлж ажиллахыг мэдэгдье.

Хавсралт ¹⁵ хуудастай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Р.БАТРАГЧАА



\\2020 on\Alban bichig\A- 5ТГ.docx

11102000058



НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ КОМИСС

Ж.Самбуугийн гудамж 13, 4 дүгээр хороо,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15140-0036
Утас/Факс: (976-51) 26-45-72
E-mail: nok_ub@yahoo.com
http://www.nobg.ub.gov.mn

ГНИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ КОМИССЫН
ГИШУУД, ГАМШГААС ХАМГААЛАХ АЛБА,
МЭРГЭЖЛИЙН АНГИ, НУТГИЙН ЗАХИРГААНЫ
БАЙГУУЛЛАГЫН ДАРГА НАРТ

2020.02.13 № 59
танай _____ -ны № _____ -т

Үүрэг хүргүүлэх тухай

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын ажилтан, албан хаагчдаас гадаад улсад албан ажлын, аяллын, эмчилгээ, хувийн ажлаар 2019 оны 12 дугаар сарын 19-нөөс 2020 оны 02 дугаар сарын 05-ны хооронд гадаадын 23 улс, Зүүн өмнөд азийн зарим орон /БНХАУ/-д дийлэнх олонх нь зорчсон байна.

Монгол Улсын Засгийн газраас Шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг 2020 оны 02 дугаар сарын 13-ны өдрөөс гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан өөрийн байгууллагын албан хаагчдыг гадаад улсад хувийн болон албаны ажлаар зорчихыг түр хориглож, дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг үүрэг болгож байна. Үүнд:

1. Шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх зөвлөмжийг хэрэгжүүлэн бэлэн байдлыг хангах, гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийж, хэрэгжүүлэх.
2. Онцгой байдлын ерөнхий газрын 2018 оны "Журам батлах тухай А/274 дүгээр тушаалаар баталсан журмын дагуу" байгууллагын үйл ажиллагааг ажлын тусгай горимд шилжүүлж ажиллах.
3. Гамшгийн зарлан мэдээллийг хүн амд шуурхай хүртээмжтэй хүргэх.
4. Гамшгаас хамгаалах хүн, хүч, хэрэгслийн тооцоо судалгаа шинэчлэн тодотгох.
5. Олон улсын хөл хориот болон халдварт бусад өвчнөөс урьдчилан сэргийлэх бүх талын арга хэмжээг зохион байгуулах.
6. Бусдын сэтгэл зүйд нөлөөлөх хуурамч ташаа мэдээ, мэдээлэлд автахгүй байх өөрийгөө болон гэр бүлээ эрсдэлээс хамгаалж урьдчилан сэргийлэх.
7. Байгууллагын бэлэн байдал, тогтвортой ажиллагааг хангаж хариуцлагатай эргүүл, жижүүр томилон ажиллуулах.
8. Байгууллагын ажилчин албан хаагчид халдвараас урьдчилан сэргийлэх үүргээ ухамсарлан нийтийн эрх ашгийг эрхэмлэж ажиллах.

ДАРГА



С.АМАРСАЙХАН



НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ КОМИССЫН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 02 сарын 18 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Нийслэлийн Онцгой комиссын 3 дугаар хурал 2020 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 15:30 цагт Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын хурлын "А" танхимд гишүүдийн 100 хувийн ирцтэйгээр хуралдав.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх талаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хангуулж нийслэлээс авч хэрэгжүүлж арга хэмжээний талаар.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нийслэлийн Засаг даргын Тамгын газар Нийслэлийн Онцгой байдлын газарт

- Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2020 оны 10 дугаар зарлиг, Засгийн газрын 2020 оны 62 дугаар тогтоолын дагуу Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт ажиллах үед төрийн болон нутгийн захиргааны байгууллага, иргэн хуулийн этгээдийн дагаж мөрдөх, хийж хэрэгжүүлэх ажлын удирдамж, салбар дундын төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хангуулж хяналт тавих.

Нийслэлийн нутгийн захиргааны нийт байгууллагуудад

- Монгол Улсын Засгийн газраас Шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор өөрийн байгууллагын албан хаагчдыг гадаад улсад хувийн болон албан ажлаар зорчихыг түр зогсоож байгууллагын бэлэн байдал, тогтвортой ажиллагааг хангах, хариуцлагатай эргүүл, жижүүр томилон ажиллуулах.

- Шуурхай ажлын хэсгийн шийдвэр зөвлөмжийн дагуу халдвараас урьдчилан сэргийлэх ажлыг шуурхай, хүртээмжтэй, чанартай зохион байгуулах.

- Шаардлагатай үед бэлэн байх багаж төхөөрөмж, эм эмнэлгийн хэрэгсэл, ариутгалын бодис материалын зардлыг Засаг даргын нөөц хөрөнгийн хүрээнд шийдвэрлэсэн асуудлаас гадна, үүссэн нөхцөл байдалд өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан шаардлагатай арга хэмжээг авч ажиллах.

- Сар шинийн баярыг тэмдэглэхгүй байх Монгол Улсын ерөнхийлөгч, Засгийн газрын шийдвэрийн хүрээнд сар шинийн өдрүүдэд үйлчилгээний байгууллагууд, зах, томоохон худалдааны төв, дэлгүүрүүдэд халдваргүйтгэл хийх, хяналт шалгалтыг сайжруулах.

- Төрийн алба хаагчид өөрсдөө худал мэдээлэлд автахгүй байж бусдын сэтгэл зүйд нөлөөлөх, өөрсдөө болон гэр бүлээ хамгаалах, иргэний үүрэг, нийгмийн хариуцлагаа биелүүлж ажиллах.

Нийслэлийн Онцгой байдлын газар,
Нийслэлийн Цагдаагийн удирдах газарт

- Сайжруулсан шахмал түлшний нөөц, хэрэглээ, сайн картын борлуулалт, түгээлтэд хөдөлгөөнт хяналт тавьж ажиллаж байгаа Мэргэжлийн хяналтын байцаагчид өөр газарт томилогдон ажиллаж байгаатай холбогдуулан хөдөлгөөнт хяналтын үйл ажиллагааг алдагдуулахгүй, сулруулахгүйгээр зохион байгуулалт хийж ажиллах.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын
Хэвлэл мэдээлэлтэй харилцах хэлтэст

- Томуу, томуу төст өвчний тархалт, шинэ коронавирусийн халдвар, шувууны томуу өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар мэргэжлийн байгууллагуудын гаргасан санамж, зөвлөмж, бодит мэдээллийг иргэд олон нийтэд өргөн хүрээнд хүргэх, үндэслэлгүй буруу ташаа мэдээлэлд автахгүй байхыг зөвлөж сэрэмжлүүлж ажиллах.

ОРЛОГЧ ДАРГА  Ж.БАТБАЯСГАЛАН



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 02 сарын 13 өдөр

Дугаар A/191

Улаанбаатар хот

Өндөржүүлсэн бэлэн байдлын үед авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 а, 29.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2020 оны 10 дугаар зарлиг, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 30, 39, 62 дугаар тогтоол, Улсын онцгой комиссын 2020 оны 01 дүгээр тогтоол, 1, 2, 3, 4 дүгээр хурлын тэмдэглэл, Нийслэлийн Онцгой комиссын 2, 3 дугаар, “Ажлын хэсэг”-ийн 1 дүгээр хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах чиглэлээр гарсан шийдвэрийг цаг алдалгүй шуурхай хэрэгжүүлэх “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн хугацаанд авч хэрэгжүүлэх арга хэмжээний удирдамж”-ийг нэгдүгээр, “Шинэ коронавирусийн халдвар, Шувууны томуу өвчнөөс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээний салбар дундын төлөвлөгөө”-г хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох байгууллагын албан тушаалтанд үүрэг болгосугай.

2.1.Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжин ажиллах үед авч хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулж, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1, 34 дүгээр зүйлийн 34.2-т заасан арга хэмжээг хэрэгжүүлж, халдварт өвчнөөс хүн амыг урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг нутгийн захиргааны нийт байгууллагуудын дарга нарт;

2.2.Улсын хэмжээнд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг ажлын тусгай горимд шилжүүлэн, хариуцлагатай эргүүл жижүүр томилон ажиллуулахыг дүүргийн Засаг дарга, нутгийн захиргааны байгууллагын болон бусад аж ахуйн нэгж, байгууллагын дарга, удирдах албан тушаалтанд;

2.3.Томуу, томуу төст өвчний тархалт, шинэ коронавирусийн халдвар, шувууны томуу өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг иргэд олон нийтэд хүргэх, бодит үнэн зөв мэдээллээр хангаж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэлтэй харилцах хэлтэс /Ц.Мөнхбаатар/-т;

111020060833

3.Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулж нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Хөгжлийн бодлогын асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Ж.Батбаясгаланд даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ



С.АМАРСАЙХАН

Нийслэлийн Засаг даргын 2020 оны
02 дугаар сарын 12-ны өдрийн
захирамжийн
1 дүгээр хавсралт

**ӨНДӨРЖҮҮЛСЭН БЭЛЭН БАЙДЛЫН ЗЭРЭГТ
ХЭСЭГЧИЛСЭН БАЙДЛААР ШИЛЖҮҮЛСЭН ХУГАЦААНД
АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ УДИРДАМЖ**

Нэг. Зорилго

Шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах чиглэлээр гарсан шийдвэрийн хэрэгжилтийг хангах, нийслэлийн төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, төлөвлөх, хүн амыг урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулахад чиглэгдэнэ.

Хоёр. Удирдлага болон хэрэгжүүлэх эрх зүйн баримт бичиг

2.1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2020 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 10 дугаар зарлиг;

2.2. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” 62 дугаар тогтоол;

2.3. Улсын онцгой комиссын 2020 оны 01 дүгээр тогтоол 01, 02, 03, 04 дүгээр хурлын шийдвэр;

2.4. Эрүүл мэндийн сайдын 2020 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн “Шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах тухай” 19 дүгээр албан даалгавар;

2.5. Нийслэлийн Засаг даргын 2020 оны “Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” А/108, “Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” А/166 дугаар захирамж, Нийслэлийн Онцгой комиссын 02, 03 дугаар хурлын шийдвэр, Ажлын хэсгийн 01 дүгээр хурлын шийдвэр.

Гурав. Зохион байгуулалтын үйл ажиллагаа

3.1. Нутгийн захиргааны нийт байгууллагын хариуцан зохион байгуулах үйл ажиллагаа.

3.1.1. Гамшгаас хамгаалах болон ажлын тусгай горимоор ажиллах төлөвлөгөө боловсруулан тодотгол хийж төлөвлөгөөний дагуу ажиллах;

3.1.2. Нөхцөл байдлын талаар болон дээд байгууллага, албан тушаалтны шийдвэр, холбогдох мэдээллийг байгууллага, салбар нэгжийн удирдлага, ажилтан, албан хаагч нарт тухай бүр мэдээлэх;

3.1.3. Байгууллага, ажилтан албан хаагчдын ажил үүргээ гүйцэтгэх нөхцөл боломжийг бүрдүүлэх, хоол хүнс, хувцас, техник хэрэгслээр хангах, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааг сахиулах, ажилтан, албан хаагчдын ажил, амралтын хуваарийг зохицуулж эрүүл мэндэд анхаарах;

3.1.4. Холбоо зарлан мэдээллийг шуурхай зохион байгуулах, байгууллага, салбар нэгжийн хэмжээнд ажиллах машин механизм, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах, шуурхай штаб, эргүүл жижүүрийг томилон удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллах, харуул хамгаалалтыг нэмэгдүүлэх;

3.1.5. Авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар аймаг, нийслэл, сум, дүүргийн Онцгой комисс болон холбогдох дээд байгууллага, албан тушаалтанд өдөр тутам танилцуулах;

3.1.6. Шаардлагатай үед байгууллага, салбар нэгжийн үйл ажиллагааг хэсэгчлэн буюу түр хугацаагаар зогсоох, хязгаарлах;

3.1.7. Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний дагуу бүрдүүлсэн нөөцийг салбар нэгжийн аюулгүй, найдвартай ажиллагааг хангахад зарцуулах;

3.1.8. Улсын болон орон нутгийн онцгой комиссын өгсөн үүрэг чиглэл, удирдамжийг хэрэгжүүлж ажиллах;

3.1.9. Байгууллагын бэлэн байдлыг хангаж, хариуцлагатай эргүүл жижүүр томилон ажиллуулах, шаардлагатай тохиолдолд шуурхай штаб байгуулах;

3.1.10. Байгууллагын өрөө тасалгаа, үйлдвэрлэл, үйлчилгээний танхим, ажилтан албан хаагчдын ариутгал халдваргүйтгэлийг тогтмол хийлгэх ажлыг нэгдсэн зохион байгуулалтаар хангах, хяналт тавьж тайлагнаж ажиллах.

3.2. Нийслэлийн Эрүүл мэндийн газрын хариуцан зохион байгуулах үйл ажиллагаа.

3.2.1. Шинэ коронавирусийн тархалтын байдалд дүн шинжилгээ хийж шаардагдах нөөцийг /эм, эмнэлгийн хэрэгсэл, хувийн хамгаалах хэрэгсэл, халдваргүйжүүлэх бодис, хүний нөөц, шатахуун, хоол, унаа, холбоо/ нэмж, тодотгох;

3.2.2. Шинэ коронавирусийн нөхцөл байдлын талаарх мэдээ мэдээллийг түргэн шуурхай дамжуулах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр үнэн зөв, баталгаатай мэдээллийг олон нийтэд хүргэх, мэдээ мэдээллийг холбогдох байгууллага, албан тушаалтанд шуурхай дамжуулах,

3.2.3. Томуу, томуу төст өвчний тархалтын болон амьсгалын замын хүнд халдварын эмнэлэгт суурилсан тандалтыг эрчимжүүлэх, эрт илрүүлэн мэдээлэх,

3.2.4. Лабораторийн болон сорьц цуглуулах, хадгалах, тээвэрлэх аюулгүй ажиллагаа, халдварын сэргийлэлт, хяналтын нөхцөл байдлыг хянаж, бэлэн байдлыг хангах;

3.2.5. Шинэ коронавируст халдварын болзошгүй тохиолдлын үед яаралтай тусламжийн болон шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, оношлуур, урвалж, ариутгал халдваргүйтгэлийн бодис, хүний нөөцийг яаралтай бүрдүүлж ажиллах;

3.2.6. Автотээврийн шалган нэвтрүүлэх товчоод дээр ажиллаж буй эрүүл мэндийн албаны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, мэргэжил арга зүйгээр хангах;

3.2.7. Томуу, томуу төст өвчин, Шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, нөхцөл байдлын мэдээг Нийслэлийн Онцгой комиссын удирдлагад тухай бүр танилцуулж байх;

3.2.8. Харьяа эрүүл мэндийн байгууллагуудын хүлээн авах, яаралтай болон түргэн тусламжийн бэлэн байдлыг нэмэгдүүлэх.

3.3. Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын хариуцан зохион байгуулах үйл ажиллагаа.

3.3.1.Авто тээврийн шалган нэвтрүүлэх товчоогоор нэвтэрч буй зорчигчдод шинэ коронавирусийн халдвараас сэргийлэх, илрүүлэх, хяналт, тандалт халдваргүйтгэл хийх ажилд хяналт тавих;

3.3.2.Худалдаа үйлчилгээ, нийтийн хоолны газруудад хийгдэж байгаа ариутгал, халдваргүйжүүлэлтийн үйл ажиллагаанд шинжилгээтэй хяналт хийх;

3.3.3.Нийтийн тээврийн хэрэгслийн цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийн үйл ажиллагаанд хяналт тавих;

3.3.4.Ерөнхий боловсролын болон их дээд сургууль, цэцэрлэг, өдөр өнжүүлэх төв, хүүхдийн тоглоомын газар, соёл урлагийн байгууллагуудын үйл ажиллагааг түр хаасан шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих;

3.3.5.Цагаан сарын баярт зориулсан олон нийтийг хамруулсан үзэсгэлэн худалдааг хаах, телевиз, радиогоор нэвтрүүлэх реклам сурталчилгааг зогсоох шийдвэрийн хэрэгжилтэд хяналт хийх;

3.3.6.Шашин сүм хийдийн байгууллага олон нийтийг хамруулсан үйл ажиллагаа явуулахгүй байх шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих;

3.3.7.Гүний гаалийн хяналтын бүсэд импортлогдож байгаа далайн гаралтай болон шувууны мах, үржлийн өндөг, хүнсний өндөг, тэжээл, бүх төрлийн хүнсний түүхий эд бүтээгдэхүүн, ачаа тээшинд хяналт тавих;

3.3.8.Худалдаа, үйлчилгээний газар (ресторан, бар, караоке)-ын ажиллах цагийн хуваарийг хязгаарлах, биелэлтэд хяналт тавьж ажиллах;

3.3.9.Шувуу болон түүний гаралтай бүтээгдэхүүнд хяналт тавьж гарал үүслийг тодорхойлох, шаардлагатай гэж үзвэл лабораторийн шинжилгээнд хамруулах.

3.4.Нийслэлийн Цагдаагийн удирдах газрын хариуцан зохион байгуулах үйл ажиллагаа.

3.4.1.Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам “Гамшгийн үеийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа” код-508-ийн 508.3.3-ийн “б”-д зааснаар “гамшгийн үед иргэдийн эрүүл мэнд, амь нас, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын эд хөрөнгийг гэмт халдлагаас хамгаалах арга хэмжээг зохион байгуулах;

3.4.2.Мөн журмын 508.3.3-ийн “в”-д зааснаар “хүн, мал, амьтны болон ургамлын гоц халдварт өвчин үүссэн үед хорио, цээрийн дэглэм тогтоож, Онцгой байдлын байгууллагатай хамтран ажиллах төлөвлөгөөг хэрэгжүүлэх.

3.5.Нийслэлийн Онцгой байдлын газрын хариуцан зохион байгуулах үйл ажиллагаа.

3.5.1.Гамшиг, аюул ослоос урьдчилан сэргийлэх, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг шуурхай үр дүнтэй зохион байгуулах;

3.5.2.Нийслэлийн Гамшгаас хамгаалах ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийж Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн хүн, хүч хэрэгслийн тооцоо судалгааг шинэчлэн тодотгох;

3.5.3.Холбоо, зарлан мэдээллийг шуурхай зохион байгуулах, байгууллага, салбар, нэгжийн хэмжээнд ажиллах шуурхай штабыг мэргэжлийн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллах;

3.5.4. Орон нутаг болон байгууллагын хүч хэрэгслийг тодотгож, шаардлагатай үед Засгийн газрын 2011 оны 340 дүгээр тогтоол болон орон нутаг байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөөний дагуу хүч хэрэгслийг хуваарилах, дайчилгаа явуулах, нүүлгэн шилжүүлэх арга хэмжээг зохион байгуулах;

3.5.5. Авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар Улс, нийслэл Онцгой комисс болон холбогдох дээд байгууллага, албан тушаалтанд өдөр тутам танилцуулах.

3.6. Нийслэлийн Мал эмнэлгийн газрын хариуцан зохион байгуулах үйл ажиллагаа.

3.6.1. Шувууны аж ахуй эрхлэгчдийн судалгааг шинэчлэн, халдварт өвчний тандалт судалгаа хийх;

3.6.2. Шувуу, шувууны гаралтай бүтээгдэхүүний Мал эмнэлгийн гэрчилгээнд хяналт тавьж, лабораторийн шинжилгээнд хамруулах;

3.6.3. Шувууны аж ахуй эрхлэгч иргэн аж ахуй нэгжид шувууны байрны эрүүл ахуйн шаардлагын талаар зөвлөмж гаргах, томуугаас сэргийлэх анхааруулга, сэрэмжлүүлэг хүргэх, байр тоног хэрэгсэлд халдваргүйтгэл хийлгэж хяналт тавих.

3.7. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэлтэй харилцах хэлтсийн хариуцан зохион байгуулах үйл ажиллагаа.

3.7.1. Шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, мэдээ мэдээллийг хэвлэл мэдээллийн бүх хэрэгслээр хүн амд шуурхай хүртээмжтэй хүргэх;

3.7.2. Цагаан сарын баяртай холбогдолтой бараа бүтээгдэхүүний зар сурталчилгааг хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон бусад хэлбэрээр түгээхийг зогсоох;

3.7.3. Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр үнэн зөв, баталгаатай мэдээллийг олон нийтэд хүргэх, мэдээ мэдээллийг холбогдох байгууллага, албан тушаалтанд шуурхай дамжуулах.

Дөрөв. Үйл ажиллагааны зардал

Коронавирусийн халдварын болзошгүй тохиолдлын үед шуурхай хариу арга хэмжээ авах үйл ажиллагааны зардлыг нийслэл, дүүрэг төсвийн зохицуулалтаар шийдвэрлэж ажиллах.



Нийслэлийн Засаг даргын 2020 оны
 13-ны өдрийн захирамжийн
 2 дугаар хавсралт

ШИНЭ КОРОНАВИРУСИЙН ХАЛДВАР ШУВУУНЫ ТОМУУ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН
 СЭРГИЙЛЭХ, ХАРИУ АРГА ХЭМЖЭЭНИЙ САЛБАР ДУНДЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хариуцах нэгж	Хамтран хэрэгжүүлэх	Хугацаа
Нэг. Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр:				
1.	Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг тодотгох	Нийслэлийн алба	НОБГ	2-3 дугаар сар
2.	Нийслэлийн Онцгой комиссын хурал, ажлын хэсгийн хурлыг зохион байгуулах, гарсан шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах	НОК	Холбогдох агентлагууд	Тухай бүр
3.	Шинэ коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангахтай холбоотой асуудлыг Улсын онцгой комисс, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх	НОК	НЭМГ, НОБГ, НМХГ, НЦУГ	Тухай бүр
4.	Шаардлагатай хүч хэрэгслийг дайчлах, байгууллага хоорондын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах	НОК	НОБГ, НЭМГ, Нийслэлийн Гамшгаас хамгаалах алба	Тухай бүр
5.	Эм, эмнэлгийн хэрэгсэл, хувийн хамгаалах хувцас, хэрэглэл, оношлуурын нөөц бүрдүүлэхэд шаардлагатай тооцоо судалгаа гаргах	НЭМГ	НОК	2 дугаар сард
6.	Зарим эм, эмнэлгийн хэрэгсэл, оношлуур, хувийн хамгаалах хувцас, хэрэглэл, тоног төхөөрөмжийн нөөц бүрдүүлэх, бэлэн байдлыг хангах	НЭМГ	НЗДТГ	2 дугаар сард

7.	Үүссэн нөхцөл байдал болон авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар мэдээлэл хийх	НЭМГ	Нийслэлийн Онцгой комиссын ажлын хэсэг, НЗДТГ-ын Хэвлэл мэдээлэлтэй харилцах хэлтэс	Тухай бүр
8.	Шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх, авч хэрэгжүүл байгаа арга хэмжээний талаар танилцуулга мэдээг Улс, Нийслэлийн Онцгой комисс, Засгийн газарт хүргүүлэх мэдээ, мэдээллээр хангах	НОБГ	НЭМГ, НМХГ, НЦУГ	Тухай бүр
9.	Эмч, ажилчдад шинэ коронавирусийн халдварын талаарх болон халдварын сэргийлэлт, хяналтын талаар гарсан тушаал, шийдвэр, АЗЦХХ, ТТӨ-ий үед баримталдаг нийтлэг арга хэмжээ, оношилгоо эмчилгээний удирдамжийг уншиж, судлуулан, мөрдүүлж ажиллах, Шинэ коронавируст халдварын тохиолдлын үед ажиллах талаар эмч, ажилчдыг дадлагажуулах дадлага сургуулийг зохион байгуулах	НЭМГ	ХӨСҮТ, ЗӨСҮТ	Тухай бүр
10.	Шуурхай штабын өдөр тутмын үйл ажиллагааг удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллах, мэдээллийн үнэн бодит байдлыг хянаж, шуурхай байдлыг хангаж ажиллах	НЭМГ	НОБГ	Тухай бүр
Хоёр. Халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр:				
11.	Нийслэлийн нутаг дэвсгэрт байрлах Авто тээврийн шалган нэвтрүүлэх товчоод дээр сэжигтэй зорчигчийг илрүүлж, эрсдэлийн түргэвчилсэн үнэлгээ, тандалт хийх, шаардлагатай тохиолдолд түр тусгаарлах, эмнэлгийн байгууллагад шилжүүлэх	НЭМГ	НОБГ, НЦУГ, НМХГ, НТУГ, НМЭГ	24-72 цагт
12.	Улс хооронд болон орон нутгийн агаарын тээвэр, Төмөр зам, автобус тээвэрт шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх талаар хяналт шалгалтыг эрчимжүүлэх, ариутгал халдваргүйтгэл хийх	НМХГ	НЦУГ, НЭМГ	Тухай бүр
13.	Халдварын шинж тэмдэг илэрсэн, хавьтлын асуумжтай иргэнээс сорьц, шинжилгээний дээж авах, шинжилгээ хийх	НЭМГ	ЗӨСҮТ	24-72 цагт
14.	Шинжилгээний хариу гартал хавьтлуудыг тусгаарлах, ажиглах, гадна орчинд хэв журам сахиулж, гаднаас иргэд, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэхгүй, хяналт тавьж ажиллах	НЭМГ, НЦУГ	НЗДТГ, НМХГ, НОБГ	Тухай бүр
15.	Тусгаарлагдсан иргэдэд сэтгэл зүйн тусламж үйлчилгээ үзүүлэх	НЭМГ	МУЗН	Тухай бүр
16.	Өвчний сэжиг илэрсэн газарт ажиллах шуурхай хариу арга хэмжээний багийг хуваарилах, хүргэх	НЭМГ	НМХГ	48 цаг

17.	Эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангуулах	НЭМГ	НЭМГ	НЭМГ	НЭМГ	Тухай бүр
18.	Шаардлагатай тохиолдолд эмнэлгийн ор дэлгэх бэлтгэл ажлыг хангах	НЭМГ	НЭМГ	НЭМГ	НЭМГ	Тухай бүр
19.	Шинэ коронавирусын эмнэлзүйн халдварын оношилгоо, эмчилгээний зөвлөх багийг томилох, сургах	НЭМГ	НЭМГ	НЭМГ	НЭМГ	2 дугаар сар
20.	Зайлшгүй шаардлагатай тохиолдолд дайчлан ажиллуулах эмч, эмнэлгийн мэргэжилтэн, бусад хүний нөөцийг сургаж бэлтгэх	НЭМГ	НЭМГ	НЭМГ	НЭМГ	2 дугаар сар
21.	Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудыг мэдээллээр хангах, сургалт зохион байгуулах	НЭМГ	НЭМГ	НЭМГ	НЭМГ	2 дугаар сар
22.	Хил, гаалийн хяналтыг сайжруулах, ажиллагсдыг халдвараас сэргийлэх хувийн хамгаалах хэрэгслээр хангах, сургалт зохион байгуулах	НМХГ, НЭМГ, НБГ	НМХГ, НЭМГ, НБГ	НМХГ, НЭМГ, НБГ	Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагууд	2-3 дугаар сар
23.	Нийслэлээс нийтийн тээврийн хэрэгслийн цэвэрлэгээ, дотор ариутгал халдваргүйтгэл, алба хаагчдын ариутгал, хамгаалах хэрэгслээр хангах, хяналт шалгалтыг зохион байгуулах	НТҮГ	НТҮГ	НТҮГ	НМХГ	2-3 дугаар сар
24.	Хот хоорондын зорчигч тээврийн хэрэгслээр зорчигчдод эрүүл мэндийн үзлэг, тандалт хийх, хяналт тавих, шаардлагатай газруудад хэв журам сахиулах	НЭМГ, НМХГ	НЭМГ, НМХГ	НЭМГ, НМХГ	НОБГ, НЦУГ	2-3дугаар сар
25.	Сэжигтэй болон хавьтагчдыг тээвэрлэн ирсэн тээврийн хэрэгсэл (нисэх онгоц, галт тэрэг, автобус, автомашин)-д эцсийн халдваргүйтгэлийг хийх	НЭМГ	НЭМГ	НЭМГ	НМХГ, ЗӨСҮТ	Тухай бүр
26.	Худалдаа, үйлчилгээний газар (ресторан, бар, караоке)-ын ажиллах цагийн хуваарийг хязгаарлах, биелэлтэд хяналт тавьж ажиллах	НЭДТГ	НЭДТГ	НЭДТГ	НЦУГ, НМХГ	2-3дугаар сар
27.	Олон нийтийг хамарсан арга хэмжээ (хурал, цуглаан, сургалт, семинар, үзэсгэлэн худалдаа, соёл, спорт, урлагийн тоглолт, бөхийн барилдаан, хурдан морины уралдаан, нийтийг хамарсан золголт, шашин номын арга хэмжээ) зохион байгуулахыг хориглох, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах	НЭДТГ	НЭДТГ	НЭДТГ	НЦУГ, НМХГ	1-3дугаар сар
28.	Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг зогсоох	НЭТГ	НЭТГ	НЭТГ	НЦУГ, НМХГ, НБГ	1-3 дугаар сар
29.	Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах	УБЗАА	УБЗАА	УБЗАА	НЭТГ, НМХГ	Тухай бүр

30.	Аж ахуй эрхлэгч зохиомлоор бараа, бүтээгдэхүүний үнийг өсгөх, үйлдвэрлэл, борлуулалтыг хязгаарлаж байгаа эсэхэд хяналт тавих, хариуцлага хүлээлгэх	НЗДТГ	НТГ, НЦУГ, НМХГ	Тухай бүр
31.	Томуу, томуу төст өвчний тархалтын болон амьсгалын замын хүнд халдварын эмнэлэгт суурилсан тандалтыг эрчимжүүлж, эрт илрүүлэн мэдээлэх	НЭМГ	Дүүргийн Нэгдсэн эмнэлэг, Эрүүл мэндийн төв, Өрхийн эрүүл мэндийн төвүүд	Тухай бүр
32.	Байгууллагаар үйлчлүүлж байгаа иргэдийн амны хаалт болон гар халдваргүйтгэх нөхцөл, бололцоог бүрдүүлэх, маскгүй иргэнд үйлчлэхгүй байх	НЗДТГ, НЭМГ	Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагууд	Тухай бүр
33.	Лабораторийн болон сорьц цуглуулах, хадгалах, тээвэрлэх аюулгүй ажиллагаа, халдварын сэргийлэлт, хяналтын нөхцөл байдлыг хянаж, бэлэн байдлыг хангах	НЭМГ	НМХГ	Тухай бүр
34.	Харьяа эрүүл мэндийн байгууллагуудын хүлээн авах, яаралтай тусламжийн бэлэн байдлыг нэмэгдүүлэх, шаардлагатай тохиолдолд эрэмбэлэн ангилалтыг хийж, зарим өвчтөнүүдийг гэрийн тусламж, үйлчилгээнд шилжүүлэх	НЭМГ	Дүүргийн Нэгдсэн эмнэлэг, Эрүүл мэндийн төв, Өрхийн эрүүл мэндийн төвүүд	Тухай бүр
35.	Худалдаа үйлчилгээ, нийтийн хоолны газруудад ариутгал, халдваргүйтгэл хийлгэх, үйл ажиллагаанд шинжилгээтэй хяналт тавих	УБЗАА	НМХГ, НМЭГ	Тухай бүр
36.	Цагаан сарын баярт зориулсан олон нийтийг хамруулсан үзэсгэлэн худалдааг хаах, телевиз, радиогоор нэвтрүүлэх реклам сурталчилгааг зогсоох шийдвэрийн хэрэгжилтэд хяналт хийх	НМХГ	НЗДТГ-ын Хэвлэл мэдээлэлтэй харилцах хэлтэс	2-3 дугаар сар
37.	Гүний гаалийн хяналтын бүсэд импортлогдож байгаа далайн гаралтай болон шувууны мах, үржлийн өндөг, хүнсний өндөг, тэжээл, бүх төрлийн хүнсний түүхий эд бүтээгдэхүүн, ачаа тээшинд хяналт тавих	НМХГ	МХЕГ	Тухай бүр
38.	Шөнийн 04:00 цаг хүртэл ажилладаг согтууруулах ундаагаар үйлчилдэг үйлчилгээний байгууллагуудад 00:00 цаг хүртэл ажиллуулах шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих	УБЗАА	НМХГ, НЦУГ	Тухай бүр
39.	Нийтийн эзэмшлийн гудамж талбайд болон олон нийтийн дунд нус цэрээ хаяж, ил задгай бие засахгүй байхыг нийслэлчүүдэд хандан уриалах, хог хаягдлыг цаг хугацаанд нь цуглуулах, тээвэрлүүлэх	УБЗАА	ХТГ, Дүүргүүд	Тухай бүр

40.	Шувууны байр тоног хэрэгсэлд халдваргүйтгэл хийлгэх, хяналт тавих	НМЭГ	Дүүргийн Мал эмнэлгийн нэгжүүд	Тухай бүр
41.	Шувууны аж ахуй эрхлэгч иргэдийн судалгааг шинэчлэн, халдварт өвчний тандалт судалгаа хийх			
Гурав. Мэдээлэл сурталчилгаа, урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар:				
42.	Эрүүл мэндийн байгууллагатай мэдээлэл солилцож, салбар хоорондын байгууллагад мэдээлэх	НЭМГ	НОБГ	2-3 дугаар сар
43.	Шинэ коронавируст халдварын талаар хүн амд зориулсан сэрэмжлүүлэг, зөвлөмж боловсруулж, харилцаа холбоо, хэвлэл мэдээллийн бүх хэрэгслээр түгээх	НЗДТГ, НЭМГ	Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагууд	Тухай бүр
44.	Бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудын эмч, сувилагч, ажилтнуудыг мэдээ, мэдээлэл, заавар зөвлөмжөөр хангах	НЭМГ	НМХГ	2-3 дугаар сар
45.	Шинэ коронавирусын талаарх хүн амын дундах ойлголт, хандлагыг тандах	НЭМГ	НТГ, НЗДТГ	2-3 дугаар сар
46.	Хүн амд чиглэсэн мэдээлэл, зөвлөмж, сурталчилгааны материал боловсруулах, түгээх, олон нийтийн хүртээл болгох	НЗДТГ	НЭМГ, НМХГ	Тухай бүр
47.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан сурталчилгааны материал бэлтгэх (дохионы хэл, брайль үсэг гэх мэт)	НЭМГ	НЗДТГ, НБГ	2-3 дугаар сар
48.	Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, цахим сүлжээ, зар сурталчилгааны самбараар вирусийн халдвараас урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг хүргэх	НЗДТГ	НЭМГ, Хэвлэл мэдээллийн байгууллагууд	Тухай бүр
49.	Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, заавар зөвлөмжийг хэрэгжүүлэх зорилгоор масс мессеж хүргүүлэх	НОК	Үүрэн холбооны операторууд	Тухай бүр
50.	Авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаарх мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол хүргэх	НОК	НЗТГ, НЭМГ	Өдөр бүрийн 11:00 цагт
51.	Үүссэн нөхцөл байдлын талаар ташаа мэдээлэл түгээж олон нийтийг төөрөгдүүлэх үйлдлийг таслан зогсоох, хариуцлага тооцох	НТГ	НЦУГ	2-3 дугаар сар
52.	Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийг онлайн болон телевизээр зохион байгуулах	НБГ	Монголын телевизүүдийн холбоо	2-3 дугаар сар
53.	Шувуу, амьтны гаралтай бүрээгдэхүүний экспортод хязгаарлалт хийсэнтэй холбогдуулан иргэдэд амьтны гаралтай	НМЭГ	НМЭГ, Хэвлэл мэдээллийн байгууллагууд	2-3 дугаар сар

	бүтээгдэхүүнээс татгалзах талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр сэрэмжлүүлэг, зөвлөж хүргэх			
Дөрөв. Бусад арга хэмжээний талаар:				
54.	Өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх үйл ажиллагааны зардал, нөхөн олговрын тайлан гаргах	НОК	Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагууд	Заагдсан хугацаанд
55.	Шуурхай штабт хариуцлагатай жижүүрээр ажиллах мэргэжилтнүүдийг мэргэжил арга зүйн дэмжлэгээр хангах, ажилтан албан хаагчдын ажил, үүргээ гүйцэтгэх нөхцөл, боломжийг бүрдүүлэх	НЭМГ	НЗТГ	Тухай бүр